МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 12 өдөр Дугаар А/194 Улаанбаатар хот

Үйл ажиллагааны төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" 2016 оны 121 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 3.1.10 дахь зорилтын 8 дугаар арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор "Эмгэг судлалын тусламж, үйлчилгээг 2017-2020 онд үндэсний хэмжээнд бэхжүүлэх, хүний нөөцийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралт ёсоор батлаcугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Эм, үйлдвэрлэл технологийн газар /Л.Мөнхтулга/, Эмгэг судлалын үндэсний төв /Г.Уянга/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон эрүүл мэндийн яамны харьяа байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тооцооллыг гарган, саналыг жил бүрийн төсвийн цагалбарын дагуу Эрүүл мэндийн яаманд ирүүлж байхыг Эмгэг судлалын үндэсний төв /Г.Уянга/, саналыг үндэслэн жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Эдийн засаг, санхүүгийн хэлтэс /Б.Пүрэвсүрэн/, Хөрөнгө оруулалтын хэлтэс /Я.Болормаа/-т тус тус даалгасугай.

4. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулж байхыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.

САЙД А.ЦОГЦЭЦЭГ

080636

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 05 сарын 12-ны өдрийн
А/194 дугаар тушаалын хавсралт

# ЭМГЭГ СУДЛАЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД БЭХЖҮҮЛЭХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /ЭМЯ 2017-2020/

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт: 3.1.10. Анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний чанарыг эрс сайжруулж, нэгдсэн эмнэлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төрөх, хүүхэд, гэмтэл, мэс заслын тусламж, үйлчилгээг өргөжүүлж чирэгдлийг бууруулна.

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | | Хүрэх түвшин | | | | Хэрэгжүүлэх байгууллага | Хамтрагч | Шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | | | |
| **1. Эрх зүйн орчинг сайжруулах хүрээнд** | | | | | | | | | |
| **1.1** | Эмгэг судлалын тусламж, үйлчилгээтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг шинэчлэх | 1.1.1 Амьд сорьц эмгэг судлалын шинжилгээ хийх журмыг шинэчлэх | Журмыг боловсруулж, батлуулж, батлуулах | Журмын хэрэгжилтэд үнэлгээ хийж, санал, зөвлөмж, гаргах | | | ЭСҮТ, Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага | ЭМЯ, ЭТГ, ХШҮДАГ | Орон нутгийн хэрэгжүүлэгч байгууллагууд үнэлгээний тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг жил бүрийн 11 дүгээр сарын |
| | | 1.1.2 Эмгэг судлалын шинжилгээ хийх журмыг шинэчлэх | Журмыг боловсруулж, батлуулах | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1.1.3 нэгдсэн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартад эмгэг судлалын тусламж үйлчилгээг сайжруулах бүтцийг тусгах | Стандартуудыг боловсруулах ажлын хэсэгт орж санал өгч, батлуулах | Стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийж, санал, зөвлөмж гаргах | | | ЭСҮТ, Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага | ЭМЯ, ЭТГ, ХШҮДАГ, | 25-ны дотор ЭСҮТ-д хүргүүлж ЭСҮТ 12 дугаар сарын 05-ны дотор нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлсэн байна. |
| | | 1.1.4 Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний стандартыг шинэчлэх болон шинээр боловсруулах | 2 стандартын төслийг шинэчлэх, 3 стандартын төслийг шинээр боловсруулж, батлуулах | 12 стандартын төслийг шинээр боловсруулж, батлуулах | 5 стандартын төслийг шинээр боловсруулж, батлуулах | 5 стандартын төслийг шинээр боловсруулж, батлуулах | ЭМЯ, ЭҮТГ, ЭСҮТ | Стандарт хэмжил зүйн үндэсний хороо | Стандартууд батлагдсан байна. |
| | | 1.1.5 Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтыг шинэчлэх | Тушаалаар батлуулах | Тушаалын хэрэгжилтэд үнэлгээ хийж, санал, зөвлөмж боловсруулах | | | ЭСҮТ, ЭМХТ, Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага | ЭМЯ, ЭТГ, ХШҮДАГ, | Тушаал батлагдсан байна. Хэрэгжилтийн тайлан. |
| | | 1.1.6 Эд, эсийн шинжилгээг ЭМД-д хамруулах | ЭМД-д хамрагдах шинжилгээний жагсаалтыг боловсруулах | ЭМД-д хамрагдах талаар эдийн засгийн тооцоог боловсруулах | ЭМД-ын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна. | | ЭМЯ, БТГ, ЭСҮТ | ХНХЯ, ЭМД-ын Үндэсний зөвлөл | ЭМД-ын үндэсний зөвлөлийн шийдвэр |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2. Хүний нөөцийг сургах, нэмэгдүүлэх ажлын хүрээнд** | | | | | | | | | |
| **2.1** | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг өргөжүүлэх | 2.1.1 Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сургалтын чиглэл, индексийн дагуу шинээр болон шинэчлэн боловсруулах | Эсийн эмгэг судлал, Хүүхдийн эмгэг судлал, Эс судлал, Эсийн лабoрторийн техникч, Эдийн лабoрторийн техникчийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах | Сургалтын эрх авсан байх | Сургалтын хэрэгцээ шаардлагын дагуу сургалт эрхлэх | Сургалтын хэрэгцээ шаардлагын дагуу сургалт эрхлэх | ЭМЯ-ны ТЗУГ, ЭМХЗ, ЭМХТ, ЭСҮТ , | Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөл, АШУҮИС | Сургалтанд хамрагдсан мэргэжилтний тоо, сургалтын тайлан |
| | | 2.1.2 Төгсөлтийн дараах сургалтын орчин, техник хэрэгслийг сайжруулах | Холбогдох эдийн засгийн тооцоо судалгааг хийж, ЭМЯ болон хамтран ажиллах байгууллагуудад санал, хүсэлт хүргүүлэх | Сургалтын орчинг сайжруулан, техник хэрэгслээр хангах | Сургалтын орчинг сайжруулан, техник хэрэгслээр хангах | Сургалтын орчинг сайжруулан, техник хэрэгслээр хангах | ЭМЯ, ЭСҮТ | Хандивлагч байгууллагууд | Сургалтын орчинг сайжруулан, техник хэрэгслээр хангагдсан байна. /Сургалтын тайлан/ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2.1.3 Эмгэг судлаач эмч нарыг гадаад оронд, төрийн санхүүжилтээр урт/төрөлжсөн мэргэшил/ болон богино /мэргэжил дээшлүүлэх/ хугацааны сургалтанд суралцуулах | Сургалтанд хамруулах талаар судалгааг хийж, хамтран ажиллах байгууллагуудад санал, хүсэлт хүргүүлэх | 2-3 мэргэжилтэнг гадаад оронд сургалтанд хамруулах | 2-3 мэргэжилтэнг гадаад оронд сургалтанд хамруулах | 2-3 мэргэжилтэнг гадаад оронд сургалтанд хамруулах | ЭМЯ-ны ТЗУГ,ЭМХЗ, ЭМХТ, ЭСҮТ, Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд | Гадаад орны сургалт эрхлэгч байгууллага, сургалтын төрийн сан | 6-9 мэргэжилтэнг гадаад оронд сургалтанд хамруулсаг байна. /хэрэгжилтийн тайлан/ |
| | | 2.1.4 Улсын хэмжээнд эмгэг судлаач эмч нарыг "Эсийн эмгэг судлал"-ын төрөлжсөн мэргэшлийн сургалтанд хамруулах | Нийслэл орон нутгаас сургалтанд хамрагдвал зохих эмч нарын 25% хамруулах | Нийслэл орон нутгаас сургалтанд хамрагдвал зохих эмч нарын 25% хамруулах | Нийслэл орон нутгаас сургалтанд хамрагдвал зохих эмч нарын,25% хамруулах | Нийслэл орон нутгаас сургалтанд хамрагдвал зохих эмч нарын 25% хамруулах | ЭМЯ-ны ТЗУГ,ЭМХЗ, ЭМХТ, ЭСҮТ, АЭМГ, БОЭТ, АНЭ | Сургалтын Төрийн сан | Эсийн эмгэг судлал"-ын төрөлжсөн мэргэшлийн сургалтанд хамруулсан байна. /Сургалтын тайлан/ |
| | | 2.1.5 Улсын хэмжээнд эмгэг судлаач эмч нарыг "Хүүхэд, эх барихын эмгэг судлал"-ын мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамруулах | Нийслэл орон нутгаас сургалтанд хамрагдвал зохих эмч нарын 25% хамруулах | Нийслэл орон нутгаас сургалтанд хамрагдвал зохих эмч нарын 25% хамруулах | Нийслэл орон нутгаас сургалтанд хамрагдвал зохих эмч нарын 25% хамруулах | Нийслэл орон нутгаас сургалтанд хамрагдвал зохих эмч нарын 25% хамруулах | ЭМЯ-ны ТЗУГ,ЭМХЗ, ЭМХТ, ЭСҮТ, АЭМГ, БОЭТ, АНЭ | Сургалтын Төрийн сан | "Хүүхэд, эх барихын эмгэг судлал"-ын мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамруулсан байна. /Сургалтын тайлан/ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2.1.6 Эсийн болон эдийн лабораторийн техникчийн төрөлжсөн мэргэшлээр мэргэжилтэн бэлтгэх | Сургалтын хэрэгцээ шаардлагын дагуу 3-4 мэргэжилтэн бэлтгэх | Сургалтын хэрэгцээ шаардлагын дагуу 3-4 мэргэжилтэн бэлтгэх | Сургалтын хэрэгцээ шаардлагын дагуу 3-4 мэргэжилтэн бэлтгэх | Сургалтын хэрэгцээ шаардлагын дагуу 3-4 мэргэжилтэн бэлтгэх | ЭМЯ-ны ТЗУГ,ЭМХЗ, ЭМХТ, ЭСҮТ, АЭМГ, БОЭТ, АНЭ | Сургалтын Төрийн сан | Эсийн болон лабораторийн техникч 9-12 мэргэжилтэн бэлтгэсэн байна. /Сургалтын тайлан/ |
| | | 2.1.7 Эх барихын эмгэг судлал чиглэлээр ажлын байрны давтан сургалтад зориулсан интерактив сургалтын материалтай болох | Эх барихын эмгэг судлалын интерактив сургалтын материалын төслийг боловсруулах | Эх барихын эмгэг судлалын интерактив сургалтын материалыг бэлэн болгох | Эх барихын эмгэг судлалын интерактив сургалтын материалаар хэрэгжүүлэгч байгууллага, мэргэжилтнүүдийг хангах | | ЭМЯ-ны ЭТГ, ЭСҮТ | ДЭМБ | Эх барихын эмгэг судлалын интерактив сургалтын материалтай болж түгээсэн байна. |
| | | 2.1.8 Олон улсын хамтарсан сургалтын сэдвийг өргөжүүлэх | Олон улсын хамтарсан сургалтын сэдвийг өргөжүүлэх бэлтгэл ажлыг хангах | Эх барих, эмэгтэйчүүдийн эмгэг судлалын сэдвээр олон улсын хамтарсан сургалтыг зохион байгуулах | Хүүхдийн эмгэг судлалын сэдвээр олон улсын хамтарсан сургалтыг зохион байгуулах | | ЭСҮТ, ЭМХТ, МСЗ, МЭЭЭСН | ДЭМБ, олон улсын нийгэмлэг холбоод | Олон улсын хамтарсан сургалтын сэдвийг өргөжүүлж сургалтуудыг зохион байгуулсан байна. |
| | | 2.1.9 Телепатолгиор дамжуулан ажлын байрны зайн сургалтыг зохион байгуулах | Зайн сургалтын тоног төхөөрмжийг суурилуулах ажлыг судлах | Зайн сургалтын тоног төхөөрмжийг суурилуулах санхүүжилтийг шийдвэрлэх | Сургалт зохион байгуулсан байна. | Сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ-ны ЭҮТГ, ЭТГ, ЭСҮТ | ДЭМБ | Телепатолгиор дамжуулан ажлын байрны зайн сургалтыг зохион байгуулсан байна. /үйл ажиллагааны тайлан/ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.2** | Улсын хэмжээнд хүний нөөцийг нэмэгдүүлэх | 2.2.1 ЭСҮТ-ийн эмгэг судлаач эмч, мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх | Стандартын дагуу эмгэг судлаач эмч, мэргэжилтнийг нэмэгдүүлэх эдийн засгийн тооцоoг гарган жил бүрийн төсөвт тусгах, бүтэц зохион байгуулалтын оновчтой болгох замаар гарц гарган шийдвэрлэх | | | | ЭМЯ-ны БТГ, ТЗУГ,ЭМХЗ, ЭЗСХ, ЭСҮТ, | Сангийн яам | Эмгэг судлаач эмч, мэргэжилтнүүдийн тоо нэмэгдсэн байна. |
| | | 2.2.2 Нийслэл, орон нутгийн эмгэг судлаач, эс судлаач эмч, мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх | Нийслэл орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд нь Стандартын дагуу эмгэг судлаач эмч, мэргэжилтнийг нэмэгдүүлэх эдийн засгийн тооцоoг гарган жил бүрийн төсөвт тусгах, бүтэц зохион байгуулалтын оновчтой болгох замаар гарц гарган шийдвэрлэх | | | | ЭМЯ, БТГ, ТЗУГ,ЭМХЗ, Нийслэл орон нутгийн эрүүл мэндийн байгууллага | Сангийн яам | Эмгэг судлаач, эс судлаач эмч нарын тоо нэмэгдсэн байна. |
| | | 2.2.3 Эмгэг судлаач эмчийн нийгмийн асуудлыг дэмжих, тогтвор суурьшилтай ажиллах орчин, нөхцөлөөр хангах | Нийгмийн асуудлыг дэмжих, тогтвор суурьшилтай ажиллах орчин, нөхцөлөөр хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | | | | ЭСҮТ, Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд | ЭМЯ | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан |
| **3.Эмгэг судлалын тусламж, үйлчилгээг сайжруулах хүрээнд** | | | | | | | | | |
| **3.1** | Тусламж, үйлчилгээний чанар | 3.1.1 ЭСҮТ нь MNS ISO 15189 стандартыг хэрэгжүүлэгч байгууллага болох | Зөвлөн туслах үйлчилгээг авсан байх, үйлчилгээ үзүүлсэн тухай гэрээ ба бусад баримт бичиг | Урьдчилсан итгэмжлэлийн багийн шалгалтанд хамрагдах, санал зөвлөмж | Хосолсон тэмдэг, гэрчилгээг авсан байна. /2 жилийн хугацаатай/ | | ЭСҮТ | ЭМЯ, Стандарт хэмжил зүйн үндэсний хороо | Хэрэгжилтийн тайлан |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.1.2 ЭСҮТ-өөс Нийслэл, орон нутгийн эмгэг судлалын тусламж, үйлчилгээнд чанарын гадаад хяналт хийх | Хяналт хийсэн тайлан | Хяналт хийсэн тайлан | Хяналт хийсэн тайлан | Хяналт хийсэн тайлан | ЭСҮТ, Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар | Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага | Үнэлгээний тайлан |
| | | 3.1.3 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн болон тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эд, эсийн лабораториудтай хамтын ажиллагааг сайжруулах | Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ батлах | Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ батлах | Хамтран шийдсэн шинжилгээний тоог нэмэгдүүлэх | Хамтран шийдсэн шинжилгээний тоог нэмэгдүүлэх | ЭСҮТ, Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд | ЭМЯ, АНЭ, НЭМГ | Гэрээний хэрэгжилтийн тухай тайлан. Хамтран шийдсэн шинжилгээний тоо нэмэгдсэн байна. |
| | | 3.1.4 ЭСҮТ-ийг Олон улсын итгэмжлэгдсэн байгууллагын чанарын гадаад хяналтанд хамруулах | Судалгаа, бэлтгэл ажил, хүсэлт илгээх | | Туршилтын хяналтанд хамрагдах | Чанарын гадаад хяналтанд хамрагдсан байна. | ЭМЯ, БТГ, ЭТГ, ЭСҮТ | Гадаад орны эрх бүхий байгууллага | Хэрэгжилтийн тайлан |
| | | 3.1.5 Нийслэл, орон нутаг дахь эмгэг судлалын тусламж, үйлчилгээнд бүсчилсэн дэмжлэгт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангах | Дэмжлэгт үнэлгээний удирдамж /шалгуур үзүүлэлт, журмыг батлуулсан байна. | Дэмжлэгт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр 30% хангасан тухай тайлан | Дэмжлэгт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр 30% хангасан тухай тайлан | Дэмжлэгт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр 30% хангасан тухай тайлан | ЭСҮТ, Нийслэл орон нутгийн эрүүл мэндийн байгууллага | ЭМЯ, ЭТГ, ХШҮДАГ, | Үнэлгээний тайланг жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор ЭМЯ-нд хүргүүлсэн байна. Санал, зөвлөмж хүргүүлсэн тухай албан бичиг |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.1.6 Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын ховор, сургамжтай, хүнд тохиолдолуудыг үндэсний хэмжээнд цахим хэлбэрээр улирал тутам хэлэлцэх | Цахим хэлэлцүүлгийн журам боловсруулан, хэрэгжүүлэх | Хэлэлцсэн тохиолдлын бүртгэл, тоо. | Хэлэлцсэн тохиолдлын бүртгэл, тоо. | Хэлэлцсэн тохиолдлын бүртгэл, тоо. | ЭСҮТ, Нийслэл орон нутгийн эрүүл мэндийн байгууллага | ЭМХТ | Цахим хэлэлцүүлгийн дүн, мэдээ, бүртгэл |
| 3.2 | Телепатологийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх | 3.2.1 Гадаад улсын эрх бүхий байгууллагаас телепатологоор зөвлөгөө авах тогтолцоог бүрдүүлэх | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх судалгаа болон эдийн засгийн тооцоог хийж, төсөвт суулгах санал өгөх | Зөвлөлдсөн тохиолдлын бүртгэл, тоо | Зөвлөлдсөн тохиолдлын бүртгэл, тоо | Зөвлөлдсөн тохиолдлын бүртгэл, тоо | ЭМЯ, БТГ, ЭСҮТ | Гадаадын эрх бүхий байгууллага | Хэрэгжилтийн тайлан |
| | | 3.2.2. Нийслэл, орон нутгийн эмгэг судлаач эмч нарт телепатологи үйлчилгээгээр зөвлөгөө өгөх, үйлчилгээг нэвтрүүлэх | ЭСҮТ-д телепатологич ажиллуулах | Зөвлөгөө өгч шийдвэрлэсэн тохиолдлын бүртгэл | Зөвлөгөө өгч шийдвэрлэсэн тохиолдлын бүртгэл | Зөвлөгөө өгч шийдвэрлэсэн тохиолдлын бүртгэл | ЭСҮТ | Эрүүл мэндийн байгууллагууд | Хэрэгжилтийн тайлан |

| 4. Тоног төхөөрөмжөөр хангах | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Улсын хэмжээнд эмгэг судлалын лабораторийг бэхжүүлэх | 4.1.1 ЭСҮТ-д иммуногистохимийн лабораторийг бэхжүүлэх | Мэргэжилтэнг бэлтгэх болон лабораторийн тоног төхөөрөмжийн хэрэгцээг тооцож, судалгаа хийх | Мэргэжилтэнг гадаад оронд бэлтгэх | Оношлуурын тоо, тоног төхөөрмжийг 20%-иар нэмэгдүүлэх | Оношлуурын тоо, тоног төхөөрмжийг 20%-иар нэмэгдүүлэх | ЭМЯ-ны ХОХ, ЭҮТГ, ЭСҮТ | ЭМЯ | Хэрэгжилтийн тайлан |
| | | 4.1.2 ЭСҮТ-ийн бүрдэл лабораторийг байгуулах бэлтгэл ажлыг хангах | Молекул гегетик, экспресс болон туршилт судалгааны лаборатори байгуулах төслийн баримт бичгүүдийг боловсруулах | Молекул генетикийн лаборатори байгуулах төслийн санхүүжилтийг шийдүүлсэн байна. | Экспресс лаборатори байгуулах төслийн санхүүжилтийг шийдүүлсэн байна. | Туршилт судалгааны лаборатори байгуулах төслийн санхүүжилтийг шийдүүлсэн байна. | ЭМЯ-ны БТГ, ХОХ, ЭҮТГ, ЭСҮТ | Сангийн яам | Хэрэгжилтийн тайлан |
| | | 4.1.3 Орон нутгийн эд, эсийн лабораторийг бэхжүүлэх | Лабораторийн тоног төхөөрөмжийн судалгааг улсын хэмжээнд хийж, зөвлөмжийг ЭМБ-дад хүргүүлэх | Орон нутгийн ЭМБ-ууд лабоаторийн тоног төхөөрөмжийг 10% хангах | Орон нутгийн ЭМБ-ууд лабоаторийн тоног төхөөрөмжийг 20% хангах | Орон нутгийн ЭМБ-ууд лабоаторийн тоног төхөөрөмжийг 30% хангах | ЭМЯ-ны БТГ, ЭҮТГ, ХОХ, аймаг , нийслэлийн эрүүл мэндийн байгууллага | Сангийн яам | Хэрэгжилтийн тайлан |